



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

**“ТАНД ОЙРХОН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” НЭЭЛТТЭЙ
ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 он


Нэг. Зорилго

1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ойртуулж төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх, салбарын бодлого, чиглэл, үйл ажиллагаа, хууль эрх зүйг сурталчлан таниулах, мэдээ мэдээлэл, зөвлөмж зөвлөгөө өгөх, санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн төр, иргэний хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд оршино.

Хатанбулаг сумын Ханги боомтын нэгдсэн эмнэлгийн хурлын зааланд 2025 оны 10 дугаар сарын 10-аас 11-ний өдрүүдэд 08:00-18:00 минут хүртэл зохион байгуулагдсан.

Хоёр. Хатанбулаг суманд төлбөрийн посс машины үйлчилгээг эхлүүллээ.

- Тус хэлтсийн зүгээс улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүндрэлгүй, түргэн шуурхай хүргэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэ удаад бүртгэлийн үйлчилгээний хураамжийг Посс машинаар дамжуулан төлөх боломжийг нэмэгдүүллээ.
- Гэрэгэ посс машинд бүртгэлтэй улсын бүртгэлийн үйлчилгээнд орон нутгийн онцлогоос хамаарсан 8 төрлийн төлбөрийн үйлчилгээг шинээр нэмэгдүүлж иргэд, олон нийтээс төлбөрийг тухай бүр авах боломжтой болж байна.
- Иргэд бүртгэлийн үйлчилгээний төлбөрөө заавал банкинд тушааж баримт авчрах биш тухайн бүртгэгчийн посс машинаар дамжуулан карт болон QR кодоор тухай бүр шуурхай төлөх боломжтой болж байгаа юм.



Гурав. Хилийн цэргийн 0168 дугаар ангийн шалган нэвтрүүлэх тасаг, авто зам, боомтын удирдлагуудтай уулзалт зохион байгууллаа.

- Хатанбулаг сумын Ханги боомтод ажиллах үеэр Хилийн цэргийн 0168 дугаар ангийн захирагчийн орлогч, боомтын дарга Ц.Баяржаргалтай уулзаж хилийн цэргийн шалган нэвтрүүлэх боомтын үйл ажиллагаатай танилцаж, үндэсний энгийн гадаад паспорт болн хил орчимын олон удаа, нэг удаагийн хэрэглээ тулгамдаж буй асуудлаар санал солилцлоо.



Дөрөв. Хатанбулаг сумын Засаг даргын орлогч, Иргэдийн төлөөлөчдийн хурлын дарга нартай уулзалт зохион байгууллаа.

- Хатанбулаг сум Иргэдийн төлөөлөгчдийн хуралын дарга Б.Билэгбаяр, сумын Засаг даргын орлогч Ч.Хишиг-Эрдэнэ нартай уулзаж “Танд ойрхон төрийн үйлчилгээ” нээлттэй хаалганы өдрийн ач тус, онцлог УБХ-ээс хэрэгжүүлсэн томоохон ажил цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар болон хамтран ажиллах чиглэлээр санал солилцлоо.
- Хатанбулаг сумын удирдлагын зүгээс улирал бүр ирж ажиллах хүсэлт тависан бөгөөд хөдөлгөөнт 4 G сүлжээний төхөөрөмжийг 10 дугаар сард багтаан шийдвэрлэж өгөхөө илэрхийллээ.



Тав. Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаа:


Улсын бүртгэлийн нэгжүүдээс үзүүлж буй улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, нэгжийн зохион байгуулалтын бүтцэд дүгнэлт хийх, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх, албан хаагчдын харилцаа хандлагыг дүгнэх зорилгоор харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааг QR код үүсгэн 2025 оны 10 дүгээр сарын 10-аас 11-ний өдөр цахимаар авав. Судалгаанд 25 харилцагч хамрагдсан.

Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийн асуулганд 100% хүссэн үйлчилгээгээ авч чадсан.



Зураг 12: “Та өөрийн хүссэн улсын бүртгэлийн үйлчилгээг бүрэн авч чадсан уу?” сэтгэл ханамжийн судалгаа

Улсын бүртгэлийн ажилтны соёл, үйлчилгээний асуулганд Улсын бүртгэлийн ажилтны харилцаа, хандлага ёс зүй, мэргэжлийн ур чадварыг 91.9% сайн гэж үнэлгээ өгсөн байна.



Зураг 13: “Улсын бүртгэлийн ажилтны харилцаа, хандлага ёс зүй, мэргэжлийн ур чадвар” сэтгэл ханамжийн судалгаа /тийм 91.9%/

Таны санал хүсэлт асуулганд улирал бүр ирж ажиллаж байх гэж санал ирүүлсэн байна.

Зургаа. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

6.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх чиглэлээр 24 иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл-1
- Үндэсний энгийн гадаад паспорт олголт-8
- Олон удаагийн хавсралт-6
- Иргэний цахим үнэмлэхийн дахин захиалга- 4
- Үндэсний энгийн гадаад паспортын зураг-4

6.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх чиглэлээр 9 иргэнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

- Цахимаар хуулийн этгээдийн нэр шалгаж цахимжуулсан-4
- Хуулийн этгээдийн чиглэлээр зөвлөгөө мэдээл өгсөн-5

Долоо. Дүгнэлт

Иргэний улсын бүртгэл хөтлөх чиглэлээр 24 иргэн, Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх чиглэлээр 9 иргэн, нийт 33 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Сэтгэл ханамжийн судалгааг иргэнээс авч нэгтгэсэн. Сумдын бүртгэгч Х.Хишигжаргалд посс машиныг хүлээлгэн өгөв. Хилийн цэргийн 0168 дугаар ангийн боомтын удирдлагууд, Хатанбулаг сумын ИТХ-ын дарга, Засаг даргын орлогч нартай уулзах уулзалтыг амжилттай зохион байгууллаа.

ТАЙЛАН БИЧСЭН :
ИУБ-ИЙН ТАСГИЙН ДАРГА,
АХЛАХ БҮРТГЭГЧ

Б.БАТТУЯА